

131 ХРИСТ ХЭН БЭ?**131.1 ЕСҮС ИРСЭН УТГА УЧРЫГ МЭДЭХ**

Есүс Христ яагаад дэлхий дээр ирэх ёстой байсан бэ?

Есүс яагаад үхэгсдээс амилах ёстой байсан бэ?

Есүс яагаад Шүүгч байх ёстой вэ?

Есүс Христ яагаад Эцэг Бурханд хүрэх цорын ганц зам вэ?

Та амьдралдаа Бурханы амласан зүйлд сэтгэл хангалуун байна уу?

Бурханы танд өгсөнийг та хуваалцдаг уу?

Та тэрхүү авралд хүрэх зам, авралыг хуваалцдаг уу?

Есүс газар дээр Хаанчлалаа байгуулахаар ирсэн.

Бурхан бүх зүйлийг хэрхэн төгсгөхийг та мэдэх үү?

Эдгээр нь одоохондоо арай болоогүй ч, магадгүй тун удахгүй.

- The Rapture
- Гурав дахь сүм
- Израилийн аврал
- Их Эзэний өдөр, дэлхий дээрх шүүлт
- Есүс Христийн хоёр дахь ирэлт
- Сатан ба муу ёрын сүнснүүдийн төгсгөл, гэм нүгэлгүй ертөнц
- Есүс Христийн дэлхий дээрх хаанчлал(мянган жил)
- Тахилчдын авах шагнал
- Цагаан сэнтийний шүүлт

- Шинэ Тэнгэр ба Шинэ Газар
- Есүс Христийн мөнхийн хаанчлал ба Түүний хүүхдүүд

131.2 ТАНЫ ХУВЬД ЕСҮС ХРИСТ ГЭЖ ХЭН БЭ?

- Таны хувьд Есүс Христ хэн бэ?
- Есүс бол Христ гэдгийг хүлээн зөвшөөрдөг хүмүүстэй Их Эзэний амласанчлан ариун сүнс хамт байдаг гэдгийг та мэддэг үү?
- Таны бие амьд сүм гэдэг нь ямар утгатай болохыг та мэдэх үү ?
- Таны доторх Ариун Сүнс хэн бэ?
- Та Ариун Сүнсээр бүрэн дүүрэн байхыг хүсдэг үү?
- Хэрхэн тийм болох вэ?
- Та Ариун Сүнсийг дагадаг уу?
- Хэрэв та Ариун Сүнсийг дагадаггүй бол дайсанд тусалж байгаагаа мэдэх үү?
- Таны эсрэг байдаг дайсныхаа төлөвлөгөөг та мэдэх үү ?

Зарлигуудыг сахих нь таныг аварч чадахгүй. Тэдгээр нь Бурханыг хэрхэн алдаршуулах тухай хэм хэмжээ юм.

БУРХАНЫ НИГҮҮЛСЭЛ ба **ӨРШӨӨЛ** мөн итгэл тань таны сүнснийг авардаг. Бурханы хүүхдүүд нь дэлхийн хүүхдүүдээс юугаараа ялгаатай вэ?

131.3. ҮГИЙГ МЭДЭХ; ХРИСТИЙГ МЭДЭХ

Үгийг мэдвэл

Христийг та мэдэх болно.

Христийг мэдвэл

хайрыг та харах болно.

Хайрыг мэдвэл хайрыг нь та хуваалцана.

Хайраа хуваалцахдаа

Бурханы алдрыг та харах болно.

Тэмдэг, гайхамшиг, эш үзүүллэгүүдийг хайхаас илүү Үгэнд заасны дагуу дуулгавартай байж, эхлээд Бурханы Үгийг тунхагла; Залбирч, Ариун сүнсний тусламжийг авах; Үгэн дотор гайхамшиг, хүч чадал оршдог.

Библи дараах зүйлийг заадаг.

- Та хэн гэдгийг
- Бурхан хэн гэдгийг
- Та одоо хаана байгааг
- Таны хаашаа явж байгааг
- Ингэснээр хэрхэн амьдрахаа та мэдэх болно.

Та амилсан Христийг хүлээн авсан уу эсвэл Тэр зүгээр л нэг түүх үү?

Бурханы Үгэн дотор хамгийн шилдэг, үнэ цэнэтэй зүйл оршдог гэдгийг та мэдэх үү?

Та Үгнээс юу олж мэдсэн бэ?

131.4 ҮГЭН ДОТОР ЭЗЭНТЭЙ УУЛЗАХ

Түүний Үгнээс уншсанаа эргэцүүлэн бодож , гүнзгийрүүлэн унш (хүлээн зөвшөөрөх, судлах, ойлгох, бясалгах, сонсох, талархал, хэрэгжүүлэх, гэрчлэл). Урт зүйлийг дэмий хоосон уншихаас илүүгээр Үгийг бясалган уншихдаа Эзэнтэй уулзах. Өглөө бүр Түүнийг сонс. Хэрэв та Эзэний дахин ирэхийг зүрхнээсээ хүсэмжилж Түүнийг чин сэтгэлээсээ эрэлхийлбэл Үгийг бясалгахдаа Түүний дуу хоолойг сонсох болно.

Ойлгоогүй зүйлээ та бясалгаж чадах уу? Бясалгахаасаа өмнө нь уншсан зүйлээ ойлго.

Биеэ Бурханы сүм гэж мэддэг учраас үүнийг цэвэр ариун, ариун байлга. Наминчилан гэмшиж , Бурханы Үгээр угаа (энэ нь ямар утгатай мөн хэрхэн гэдгийг мэдэх үү?)

Нарийн хаалгаар[Есүс] [анхаарлаа төвлөрүүлж] болон нарийн замаар[Үг] аялах хэрэгтэй. Цаг нь болохоор ялалт ба үр жимснүүд гарч ирнэ. Тиймээс сонссон зүйлээ хойшлуулалгүйгээр зуурах хэрэгтэй.